



2023

ҮР НӨЛӨӨНИЙ ТАЙЛАН



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

(СОГЭ)

Эдийн Засгийн Ногоон Шилжилт

АНУ

Америкийн Нэгдсэн Улс

ББСБ

Банк Бус Санхүүгийн Байгууллага

БЖДҮ

Бичил Жижиг Дунд Үйлдвэрлэл

ЖДБ

Жижиг Дунд Бизнес

ЖДБЭ

Жижиг Дунд Бизнес Эрхлэгч

МАА

Мал Аж Ахуй

НЖДҮҮДТ

Нийслэлийн Жижиг Дунд Үйлдвэр, Үйлчилгээг Дэмжих Төв

НҮБ

Нэгдсэн Үндэстний Байгууллага

НЭНЭЗ

Нийгэм Эв Нэгдлийн Эдийн Засаг

ОУТББ

Олон Улсын Төрийн Бус Байгууллага

ОУХБ

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага

ТББ

Төрийн Бус Байгууллага

ТОС

Тогтвортой Санхүүжилтийн Холбоо

УБ

Улаанбаатар Хот

УЗ

Удирдах Зөвлөл

ХХК

Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

АГУУЛГА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

4

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

5

БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

6

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ САЛБАРУУД

6

ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛ

7

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

10

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН /FACTSHEET/

11

ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

12

ХАМТРАГЧ ТАЛУУД

58

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт харилцагчид, түншүүд, удирдах зөвлөлийн гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Хөгжлийн Шийдэл ТББ нь Улаанбаатар хот, аймгийн төвүүд, зарим сумдад байрлах 15 салбараар дамжуулан бизнес эрхлэгчдийн асуудал бэрхшээлийг нь шийдэх, боломжийг нь нэмэгдүүлэх зорилготойгоор ажиллаж байна.

2023 онд бид нийт 17,479 харилцагчийг сургалт, уулзалт, зөвлөх үйлчилгээ, менторинг, хөгжүүлэх хөтөлбөрүүдэд хамруулснаар 62.6 тэрбум төгрөгийн зээлийг зуучилж, 1,500 ажлын байрыг шинээр бий болгоход хувь нэмэр оруулсан. Энэ бүхний ард манай байгууллагын ажилтнууд болон харилцагчдын маань хамтын хүчин чармайлт, түншлэгч байгууллагуудын үр дүнтэй, нягт хамтын ажиллагаа байсныг дурсахад таатай байна.

Тухайлбал Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилттэй “Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх” (BEST) хөтөлбөр-ийн үйл ажиллагаа нь импортыг орлох чадавхтай ЖДБ-үүдэд төвлөрч ажиллалаа.

Оюу Толгой ХХК-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Орон Нутгийн Хөдөө Аж Ахуйн Бизнесийг Дэмжих” хөтөлбөр дөрөв дэх жилдээ амжилттай хэрэгжиж, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт малчдад дундын хоршоо байгуулах, махны үйлдвэр байгуулахад зөвлөгөө өгч ажиллалаа. Энэ нь Монгол улсад анх удаа нэг сум-нэг хоршоо санаачилгыг бодитоор хэрэгжүүлж, нэг сумын бүх малчид хамтран өөрийн гэсэн махны үйлдвэр байгуулах бодит алхам боллоо. Энэ сайн туршлагыг Монгол улсын 330 суманд түгээх боломжтой.

Европын Холбооны SWITCH Asia хөтөлбөрийн санхүүжилттэй “Эдийн Засгийн Ногоон Шилжилт” (СОГЭ) төслийг Пипл Ин Нийд ОУТББ, Каритас Чех Репаблик ОУТББ (КЧР) болон Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоотой хамтран Улаанбаатар, Эрдэнэт болон Сэлэнгэ аймагт хэрэгжүүлж 190 ЖДБ эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлсэн байна. Энэхүү төсөл нь 2025 он хүртэл хөдөө аж ахуйн хүнс болон шингэн хүнсний салбарын БЖДҮ болон жижиглэн худалдаа эрхлэгчдэд тохирсон дэмжлэг, техникийн туслалцаа үзүүлэх, зах зээлд суурилсан ногоон шошго олгох системийг хөгжүүлэн хэрэглэгчдийн хандлагыг өөрчлөх, ногоон санхүүжилтийн хүртээмжээр хангах замаар тойрог эдийн засагт шилжихэд нь дэмжлэг үзүүлэн ажиллана.

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Улаанбаатар хот, Архангай, Хөвсгөл аймгуудад хэрэгжүүлж буй “ТЭЗ ба Ногоон бизнесийн чиглэлд аялал жуулчлалын салбарт БЖДБЭ-ийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээ” төслийн хүрээнд 767 ЖДБ-д үйлчилгээ үзүүлсэн.

Ирэх 2024 онд малчид, гарааны бизнес, ЖДБ эрхлэгчид, уурхайн ханган нийлүүлэгчдэд тулгарч буй асуудал бэрхшээлийг шийдэх чиглэлээр хэн бүхэнтэй хамтран ажиллахад бэлэн байна.

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ **П.АМАРМЭНД**

УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хөгжлийн Шийдэл ТББ-ын Удирдах Зөвлөл нь орон нутгийн хөгжил, бизнес, эдийн засгийг хөгжүүлэх зорилго чиглэлийг нийгмийн хариуцлагынхаа хүрээнд дэмждэг хууль эрх зүй, боловсрол, банк санхүү болон уул уурхайн салбарын төлөөллүүд бүхий хараат бус 5 гишүүдээс бүрддэг. Удирдах Зөвлөл нь жилд дөрвөн удаагийн ээлжит хурлыг зохион байгуулж, стратегийн болон цаг үеийн зохих шийдвэрүүдийг гаргах үүрэг бүхий удирдах дээд байгууллага юм.



Удирдах зөвлөлийн дарга
Лувсандоржийн Оюун
МУИС-ийн БС-ийн Санхүүгийн
Хөтөлбөрийн багш доктор Профессор



Удирдах зөвлөлийн гишүүн
**Жигжидсүрэнгийн
Гантөмөр**
Хаан Банк Зээлийн бодлого
зохицуулалтын газрын төслийн
зээлийн ахлах менежер



Удирдах зөвлөлийн гишүүн
**Зоригийн
Туяа**
Нью-Урбанизм ХХК Захирал



Удирдах зөвлөлийн гишүүн
Жуковын Баатарболд
Тэнгэр Даатгалын Гүйцэтгэх захирал



Удирдах зөвлөлийн гишүүн
**Жамбалдоржийн
Эрдэнэчимэг**
Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны
Ерөнхийлөгч асан

БИД

Хөгжлийн Шийдэл ТББ нь 2008 оны 8-р сарын 14-ний өдөр үүсгэн байгуулагдсанаасаа хойш хэрэгжүүлж ирсэн **100 орчим төсөл** хөтөлбөрөөрөө дамжуулан харилцагч бүрийнхээ өсөлт, дэвшлийн хөшүүрэг нь болж, бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих энтрепренёр сэтгэлгээ, хандлага, бизнесийн ур чадвар, борлуулалтын зах зээл, санхүүжилттэй холбох зэрэг олон талын цогц үйлчилгээг үр дүнтэй үзүүлж байгаа мэргэшсэн хамт олон юм.

Манай байгууллага нь одоогоор **15** салбарын хүрээнд нийт **71** ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа

Улаанбаатар салбарт **37** ажилтан, орон нутгийн **14** салбарт **34** ажилтан ажиллаж байна.

Алсын хараа

Хөгжлийн Шийдэл нь бизнесийн хөгжлийг дэмжих мэргэжлийн цогц үйлчилгээг үзүүлэгч **ШИНЭЛЭГ, ҮР ДҮНТЭЙ, ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА** байна.

Эрхэм зорилго


Өрх гэрийн амьдралын чанарыг сайжруулна
Өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхыг бий болгоно
Байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ

Үнэт зүйлс

Хөгжлийн Шийдэл ТББ нь
➤ **АШГИЙН БУС, БИЕ ДААСАН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА** ЮМ.
➤ **ХАРИЛЦАГЧ НЭГ БҮРИЙН ХЭРЭГЦЭЭНД ТОХИРСОН ҮНЭ ЦЭНТЭЙ, ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН БИЗНЕС ХӨГЖЛИЙН УРТ ХУГАЦААНЫ ЦОГЦ ШИЙДЛИЙГ ӨРГӨН ХҮРЭЭГЭЭР ҮЗҮҮЛДЭГ.**

Хөгжлийн Шийдэл ТББ-ын ажилтан бүр
➤ **ҮР ДҮНТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭРХЭМЛЭДЭГ БӨГӨӨД ДЭЛХИЙД ТАНИГДСАН БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН АРГА, ТУРШЛАГААР МОНГОЛ УЛСЫН БИЧИЛ БОЛОН ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН ЧАДАВХЫГ ХӨГЖҮҮЛЭХ УР ЧАДВАРТАЙ.**

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ САЛБАРУУД



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД



БИЧИЛ, ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧ

ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЛЭГЧ

ХУВИАРАА БИЗНЕС ЭРХЛЭГЧ

ЗАЛУУ БИЗНЕС ЭРХЛЭГЧ

ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧ



МАЛЧИН, МАЛЧДЫН ХОРШОО

БИЗНЕС ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА





БИДНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ



БИЗНЕС ХӨГЖЛИЙН
СУРГАЛТЫН
ҮЙЛЧИЛГЭЭ



БАЙГУУЛЛАГЫН
УДИРДЛАГА,
АЖИЛТНУУДАД
ЗОРИУЛСАН СУРГАЛТ



МЕНЕЖМЕНТИЙН
БОЛОН ЗАСАГЛАЛЫН
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГЫГ
ЧАДАВХЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭ



БИЗНЕСИЙН
БҮЛЭГ, ХОРШООГ
ХӨГЖҮҮЛЭХ
ҮЙЛЧИЛГЭЭ



БОРЛУУЛАЛТЫН
ХОЛБОЛТЫН
ҮЙЛЧИЛГЭЭ



БИЗНЕС, ЭДИЙН
ЗАСГИЙН СУДАЛГАА



ЗЭЭЛ
САНХҮҮЖИЛТЭД
ХОЛБОХ
ҮЙЛЧИЛГЭЭ



МЕНТОРИНГ, КӨҮЧ



ТӨРИЙН АЛБАН
ХААГЧДЫГ
ХӨГЖҮҮЛЭХ



ГАРААНЫ БИЗНЕСИЙГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР



Үйл
ажиллагааны
үр дүн

№		2023	2008-2023 үйл ажиллагааны үр дүн
1	 ШИНЭ БИЗНЕС	316	5,740
2	 ӨРГӨЖИН САЙЖИРСАН БИЗНЕС	1583	14,741
3	 ШИНЭЭР БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР	1283	25,179
4	 СУРГАЛТАД СУУСАН ХҮМҮҮСИЙН ТОО	17986	62,431
5	 МЕНТОР	609	1,937
6	 БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ӨСӨЛТ	15.6 тэрбум	44.1 тэрбум
7	 АМЖИЛТТАЙ ЗЭЭЛИЙН ЗУУЧЛАЛ	99.3 тэрбум	342.5 тэрбум
8	 АМЖИЛТТАЙ ЗУУЧИЛСАН БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТОО	1310	12,080
9	 БИЗНЕСИЙН БҮЛЭГ ХОРШОО, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА	56	812
10	 16-35 НАСНЫ БИЗНЕС ЭРХЛЭГЧИД	5546	26,517



ZEEG - ЗЭЭГ

01. DELICIOUS

Өдөр тутам идэхэд зовлонгүй хурц амтгүй, тааламжтай байх ёстой. Prototype шатанд яваа.

CU

02. ACCESSIBLE

Худалдаж авахад ойрхон бөгөөд хүндрэлгүй байх ёстой тул Convenience store-д байршуулна.

GS25

02

01

Ашиг олж

03

04

03. PROFITABLE

Түүхийг өөрсдөө тарьж худалдаж авч, өөрсдөө худалдан авагчдын санхүүд хүндрэлгүй.

04. NUTRITIOUS

Эслэг кали, уургаар баялаг чаналтын арга барил нь түүхий эдийн шим тэжээлийг бууруулахгүй байхаар тохируулагдсан.



01. RESPONSIBLE PRODUCTION

Material footprint reduction
Түүхий эдийн тээвэр, түгээлтийн тээвэр хамгийн бага.

13

13


Test

VS

Нийгэмд түстэй

04. PROMOTE WELL-BEING

Хүнсчээс авах аюул шим тэжээлийн 1/3 бууруулахгүйн шар ангийн жамсгад хийсэн.



BEST ХӨТӨЛБӨР

2019-2024 он

**ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ
АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ
ДЭМЖИХ ТӨСӨЛ**

2018-2024 он

**ТЭЗ БА НОГООН БИЗНЕСИЙН ЧИГЛЭЛД
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ БЖДБЭ-ИЙГ
ЧАДАВХЖУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ**

2023-2024 он

**ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН
ШИЛЖИЛТ - SOGE ТӨСӨЛ**

2022-2025 он

**ЗАЛУУЧУУДЫН БИЗНЕСИЙН
САНААЧИЛГА -YBM**

2013 оноос
одоог хүртэл

**АЗИ ДАХЬ НИЙГЭМ, ЭВ НЭГДЛИЙН ЭДИЙН
ЗАСГИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ СУДАЛГАА**

2022-2025 он

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР**

2010 оноос
одоог хүртэл


БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ
САЙЖРУУЛАХ, ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

BEST

ХӨТӨЛБӨР

“ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙН
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ
САЙЖРУУЛАХ, ИЛ ТОД БАЙДЛЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ”
BEST ХӨТӨЛБӨР

2019-2024 он



BEST ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУД

Хөгжлийн Шийдэл ТББ нь USAID-ийн санхүүжилттэй BEST хөтөлбөрийг 4 дэх жилдээ амжилттай хэрэгжүүлж байгаа ба ЖДБ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн сайн засаглал, хариуцлага, ил тод байдлыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэн өсгөх зорилготой. BEST хөтөлбөр нь Улаанбаатар хот, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Ховд, Хэнтийн аймгууд гэсэн нийт **13** салбарт үйл ажиллагаа явуулж байна.

2023 оны хувьд **BEST** хөтөлбөр нь Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарын бизнесүүдийг чадавхжуулах чиглэлээр үйл ажиллагаагаа төрөлжүүлэн ажилласан.

1.
ЖДБ-ИЙН
САНХҮҮЖИЛТ
АВАХ БОЛОМЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ

2.
ЖДБ-ИЙН
ЗАСАГЛАЛЫГ
САЙЖРУУЛАХ

3.
ЖДБ-ИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ
ДЭМЖДЭГ ТӨРИЙН
БОЛОН ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГУУДЫН
ИЛ ТОД БАЙДЛЫГ
ХАНГАХ, ХЯНАЛТЫН
ТОГТОЛЦООГ
БЭХЖҮҮЛЭХ

4.
БИЗНЕСИЙН
ХӨГЖЛИЙН
СТРАТЕГИЙГ
ТОДОРХОЙЛОХОД
ЧИГЛЭСЭН
СУДАЛГААГ ХИЙХ

5.
БИЧИЛ
САНХҮҮЖИЛТИЙН
ТЭТГЭЛЭГТ
ХӨТӨЛБӨР

ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Чадавхжуулах сургалт
2. Урт болон богино хугацааны зөвлөх үйлчилгээ
3. Менторинг үйлчилгээ
4. Зээл, санхүүжилтийн зуучлал
5. Бичил тэтгэлгийн санхүүжилт
6. Судалгаа
7. Форум
8. Уулзалт, хэлэлцүүлэг
9. Сургалтын материал, гарын авлага
10. Ном, сонин, товхимол
11. Bizguide.mn онлайн платформ

ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

BEST

ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Тайлант хугацаанд BEST хөтөлбөрийн зохион байгуулсан 935 удаагийн чадавхжуулах сургалтад **14,991** хүн, **423** удаагийн мэдлэг, туршлага хуваалцах уулзалт, хэлэлцүүлэгт **11,764** хүн хамрагдсан байна.

Зорилт 1

Зээл санхүүжилт авах чадамжийг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөө болон зээлийн зуучлалын үйлчилгээний үр дүнд **103.69 тэрбум** төгрөгийн зээлийг банк санхүүгийн байгууллагаас авахад нь тусалсан байна.

Зорилт 2

Урт хугацааны засаглалын зөвлөх үйлчилгээнд **67** аж ахуй нэгж, богино хугацааны засаглалын зөвлөх үйлчилгээнд **151** аж ахуй нэгж хамрагдаж нийт **218** харилцагч засаглалаа сайжруулсан байна.

Зорилт 3

ЖДБ-ийн үйл ажиллагааг дэмждэг төрийн болон ТББ-ын ил тод байдлыг хангах, хяналтын тогтолцоог бэхжүүлэх сургалт, уулзалт, нөлөөллийн ажлын үр дүнд **6** удаагийн санал, санаачилгыг гаргасан байна.

Зорилт 4

Жижиг дунд бизнес, хүнс, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийн нөхцөл байдал, өрсөлдөх чадвар болон тулгарч буй түгээмэл асуудлыг илрүүлэх зорилгоор нийт **7** төрлийн судалгаа хийсэн байна.

Зорилт 5

Орон нутагт бичил тэтгэлэг олгох зорилтын хүрээнд орон нутгийн онцлогт тохирсон шинэлэг санаа бүхий **34** гарааны бизнес, **27** ЖДБ-т **586** сая төгрөгийн санхүүжилтийн тэтгэлэг олгосон.

Зорилт 1. ЖДБ-ИЙН САНХҮҮЖИЛТ АВАХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

ЗЭЭЛИЙН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ХУРДАСГУУР ХӨТӨЛБӨР

- Бизнес төсөл
- Төслийн санхүүгийн төлөвлөлт
- Зах зээлийн судалгаа
- Бизнес загвар
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сав баглаа боодол
- Төслийн танилцуулга хийх
- Байгал орчин менежментийн сургалт

Зээл санхүүжилтийн боломжуудын талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр олон төрлийн зээлийн гарын авлага хэвлэгдэн гарсан байдаг хэдий ч хөдөө аж ахуйн салбарт олгогдож буй зээлийн талаар нэгдсэн товхимол хараахан гараагүй байсан нь ХАА-н бизнес эрхлэгчдийн зээл санхүүжилтэд хамрагдах боломжийг бууруулж байсан. Иймд BEST хөтөлбөр нь 2023 онд хөдөө аж ахуйн чиглэлээр зээл санхүүжилтийн гарын авлагыг боловсруулан гаргаж бизнес эрхлэгч нарт орон нутаг даяар түгээлээ.

ЖДБ-ийн санхүүжилтийн хүртээмжийг хурдасгуур болон дэд хөтөлбөрүүдээр дамжуулан нэмэгдүүлсэн

ЖДБ-үүдийн мэдлэг, туршлага хуваалцах нөхцөлийг хангах, бизнес хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгох боломжийг нэмэгдүүлэх үндсэн зорилгын хүрээнд тайлант хугацаанд бизнесийг хөгжүүлэх **Scale up, Green Lab, 5X, Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, ХАА-н ЖДБ эрхлэгчдийг дэмжих** зэрэг Хурдасгуур хөтөлбөрүүдэд хамрагдсан ЖДБ нар, мөн Захирлуудын клубын гишүүн ЖДБ эрхлэгч нарын **175 хүн** оролцсон **8 удаагийн сургалтын** аялал зохион байгуулав.



Сургалтын аяллын хүрээнд ажлын байрны зохион байгуулалт, сайн засаглал, чанарын удирдлага, хяналтын тогтолцооны талаарх мэдлэг, туршлагаа хуваалцаж, бизнес хооронд түүхий эд бүтээгдэхүүн нийлүүлэх, хог хаягдлыг бууруулах, нөөцийг хамтран эзэмших зэрэг стратегийн түншлэл, хамтран ажиллах бизнес саналуудыг солилцсон байна.

Зорилт 2. ЖДБ-ИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ

ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН КЛУБ БАЙГУУЛАХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛСЭН

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн нэг гол ажил нь Эмэгтэй бизнес эрхлэгчдийн клуб байгуулах ажил байсан бөгөөд BEST хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр **12** Аймагт **235** гишүүдийг хамруулсан клубүүд байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний үр дүнгээс дурьдвал:

Дорноговь аймгийн эмэгтэй захирлуудын клуб

BEST хөтөлбөрийн захиалгаар “Говийн хөх салхи” ТББ-ийн гүйцэтгэсэн “Орон нутгийн бизнес эрхлэгчдийн мэдээллийн дата сан бүрдүүлэх, бэрхшээлийг тодорхойлох судалгааны ажил”-ыг хүлээж авсан. “Дорноговь аймгийн эмэгтэй захирлуудын клуб” тус судалгааны үр дүнг үндэслэн “Дорноговь аймагт эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр” шаардлагатай гэж үзэж BEST хөтөлбөртэй хамтран төрийн болон төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчдээс санал авах уулзалтууд зохион байгуулсан. Үүний үр дүнд Дорноговь аймгийн ЗД-ын захирамжаар төр болон төрийн бус байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн үр дүнд аймгийн бичил, жижиг дунд үйлдвэр, худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийг тогтвортой хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой “Түншлэл ба хөгжил” хөтөлбөр боловсруулж 2023.12.05-нд Дорноговь аймгийн



ИТХурлаар батлууллаа. Хөтөлбөрийг дөрвөн жилийн хугацаатай хэрэгжүүлэх бөгөөд улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө, хувийн хэвшил болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 онд 2 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр боллоо.

Амжилтын түүх

ДОРНОД СЕО КЛУБ

АНУ-ын ОУ-н Хөгжлийн агентлагийн санхүүжилтэй Хөгжлийн Шийдэл ТББ-ийн хэрэгжүүлж байгаа BEST хөтөлбөрийн компанийн засаглалын сургалт, зөвлөгөө авсан компаниуд нэгдэх, хамтрах талаар олон санаачилгууд гарган ажиллаж байгаагийн нэг илрэл нь хамтдаа хөгжих, хамтаараа асуудлуудаа шийдвэрлэх зорилготой захирлуудын клуб билээ. Энэ удаад онцолж байгаа CEO клуб бол BEST хөтөлбөрийн Дорнод салбарын дэргэд байгуулагдсан ДОРНОД СЕО клуб юм.

Эрхэм зорилго:

Эмэгтэйчүүдийн хамтын ажиллагааг идэвхжүүлэн бизнесийн хөгжлийг дэмжиж, нийгэм эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэн, манлайлалд хөтөлнө.

Дорнод СЕО клуб нь одоогийн байдлаар 30 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд 5 сургалт, 4 уулзалт, 2 удаагийн бизнес аялал, үзэсгэлэн худалдаа гэсэн гишүүдийнхээ мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, бизнесийнхээ түншлэлийн цар хүрээг тэлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх 10 гаруй үйл ажиллагаа зохион байгуулсан байна.



Зорилт 3. ЖДБ-ийн ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖДЭГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙВ

Жижиг, Дунд Үйлдвэрийн Газартай хамтран ЖДҮХС-н хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалтын одоогийн үнэлгээний систем нь бодит байдалтай нийцтэй байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор хөндлөнгийн үнэлгээний ажлыг зохион байгуулсан. Хөндлөнгийн үнэлгээний ажлын хүрээнд төсөл сонгон шалгаруулах үнэлгээний аргачлалын үе шат, сонгон шалгаруулах үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн зохистой харьцаа, онооны оновчтой хуваарилалт болон чанаргүй зээлдэгчдийн учир шалтгааны тодорхойлох ажлуудыг зохион байгуулсан. Мөн ЖДҮХСангийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банк болон Банк бус санхүүгийн байгууллагын үнэлгээний аргачлалтай харьцуулсан дүгнэлтийг боловсруулсан. Хөндлөнгийн үнэлгээний хүрээнд үндсэн 2 чиглэлд тодорхой зөвлөмжүүдийг боловсруулж, Жижиг Дунд Үйлдвэрийн Газрын дарга Я.Эрдэнэсайхан, Зээл төслийн хэлтсийн дарга Н.Энхтөр нарт биечлэн танилцуулсан. Жижиг дунд үйлдвэрийн газар нь энэхүү зөвлөмжүүдтэй нарийвчлан танилцаж, цаашид хэрхэн хэрэгжүүлж болох талаар хэлэлцүүлгийг Жижиг дунд үйлдвэрийн газрын холбогдох хэлтэс, тэдгээрийн мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулахаар болсон.

Амжилтын түүх

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ТӨРӨӨС ОЛГОГДОЖ БАЙГАА ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛҮҮДИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАВ

Хөгжлийн Шийдэл ТББ нь Дархан-Уул аймгийн Бизнес судлалын төв ТББ-тай хамтран “Төрийн байгууллагын зүгээс ЖДБ эрхлэгчдэд олгож байгаа хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн ил тод байдал, хүртээмжийн үнэлгээ”-ний үр дүнд Дархан-Уул аймгийн ЗДТГ-т танилцуулснаар Засаг дарга Б.Азжаргал холбогдох байгууллагуудад үүрэг өгч Дархан-Уул аймгийн хэмжээнд ЖДҮХС, Хоршоо хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангуудын мэдээллийг дэлгэрэнгүй тайлбарлах, таниулах нээлттэй хэлэлцүүлгүүдийг цувралаар зохион байгуулав. Үүний үр дүнд Дархан-Уул аймгийн хэмжээнд 2023 оны сүүл хэсэгт олгогдох Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 176 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн 270 сая, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн мэдээллийн хүртээмж нэмэгдэж, хамрагдалт өснө гэж үзэж байна. Шийдвэр гарснаас хойш хийгдсэн ажлуудаас дурдвал дараах байдалтай байна. Үүнд:



Дархан-Уул аймгийн
Засаг дарга Б.Азжаргал

- Төрөөс олгогдож байгаа хөнгөлөлттэй зээлүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг хариуцсан ажлын хэсгийг байгуулсан.
- Аймгийн ЗДТГ-ийн байранд нэг өдрийн турш ХХААГ, ХХСангийн мэргэжилтнүүдийг байлцуулж мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулж, жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүжилттэй холбоотой зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан.
- ЖДҮХС, ХХС зэрэг санхүүжилтийн сонгон шалгаруулалтын процесст мэргэжлийн багийн санал, хяналтыг бий болгож, үр дүнг сонгон шалгаруулалтын хороонд хүргүүлдэг байхаар шийдвэрлэсэн.

Зорилт 4. БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛОХОД ЧИГЛЭСЭН СУДАЛГАА

БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛОХОД ЧИГЛЭСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ОЛОН НИЙТЭД ХУВААЛЦАВ



Монгол Улсын хувьд Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийн судалгаа, мэдээллийн олдоц олон нийтийн дунд хангалтгүй байдаг бөгөөд USAID-н BEST хөтөлбөр нь бодлого боловсруулагчдад ЖДҮ-н нөхцөл байдлыг ойлгуулах, нотолгоонд суурилсан бодлого шийдлийг тодорхойлоход туслах зорилгоор судалгааны ажлуудыг хийсээр ирсэн билээ.


2023 оны 6-р сарын 8-нд BEST хөтөлбөрөөс төр, хувийн хэвшил, бизнес эрхлэгчид, олон улсын болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлд "Хөдөө аж ахуйн суурь судалгаа" болон "Жижиг, дунд бизнесийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал судалгаа"-ны голлох үр дүнгүүдийг танилцуулах уулзалтыг амжилттай хэрэгжүүлсэн. Уулзалтад нийт 50 оролцогч хамрагдсан байна.

Зорилт 5. БИЧИЛ САНХҮҮЖИЛТИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Энэхүү зорилтын хүрээнд бид 2023 онд нийт 61 гарааны болон ЖДБ эрхлэгчдэд 586 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ төслөө амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхжуулах 18 цагийн хурдасгуур хөтөлбөрт хамрууллаа.



Нийт тэтгэлэг хүртэгчийн **78% буюу 48** нь эмэгтэй бизнес эрхлэгчид байгаа нь онцлог байна.



Хийгдсэн судалгааны нэр	Судалгааны байгууллагын нэр	Судалгааны байршил	Түүвэр		Тоо	
			Хийгдсэн огноо	Сонгосон бүлэг		
	ХАА суурь судалгаа	INRAE	BEST салбарууд	2023 оны 1-р улирал	ЖДҮ сектор (ХАА бизнесүүд)	800
	Жижиг дунд бизнесийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал	SICA	BEST салбарууд	2023 оны 1-р улирал	ЖДҮ сектор	1024
	Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварын судалгаа	IRIM	21 аймаг	2023 оны 2-р улирал	ЖДҮ сектор, бизнесийн экосистем, макро орчин	703
	Албан бус эдийн засгаас Албан эдийн засгийн шилжилт: Сорилт ба боломжууд судалгаа	SICA	BEST салбарууд	2023 оны 3-р улирал	ЖДҮ сектор	768
	ХАА салбарын санхүүжилтийг загварчлах нь	Banking and Finance Academy	Улаанбаатар	2023 оны 2-р улирал	Банк санхүүгийн байгууллагууд	N/A
	Оёдлын салбарын нөхцөл байдлын судалгаа	NRCC	BEST салбарууд	2023 оны 4-р улирал	ЖДҮ сектор	100
	ХАА бизнесийн нэмүү өртгийн сүлжээг үнэлэх нь	INRAE	BEST салбарууд	2023 оны 4-р улирал	ЖДҮ сектор	N/A

Бизнесийн
ангиллаар

ЖДҮ

 Хувиараа
бизнес
эрхлэгч

 Тэтгэлэг
хүлээн авагч

27

34

 Тэтгэлгийн
дүн ₮

260,873,720

325,207,000

Бичил санхүүжилтийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд нийт 34 хувиараа бизнес эрхлэгч буюу албан бус бизнес эрхлэгч тэтгэлэг авсан байгаа нь орон нутгийн бизнес эрхлэлтийн нөхцөл байдалтай холбоотой юм. BEST хөтөлбөрийн бусад зорилтуудтай уялдаа холбоотойгоор эдгээр бизнесийг албан бизнес болгон өргөжүүлсэн.

Төслийн 4-р жилд BEST хөтөлбөр нь Хөдөө аж ахуйн бизнесийг онцолсон бөгөөд нийт тэтгэлэг авсан харилцагчдын **48** бизнес эрхлэгч нь хөдөө аж ахуйн бизнес, үнийн дүнгээр **466.4 сая** төгрөгийн тэтгэлэг олгосон нь нийт дүнгийн **74%** байна.

Амжилтын түүх

2023 ОНД ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРТ “KHUU STREET FOODS” ТӨСЛӨӨРӨӨ ШАЛГАРЧ, САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ АВСАН Н.ОЧИРБАТ:



Иргэнээр, 2 тоног төхөөрөмжтэйгөөр бизнесээ эрхэлж байсан бөгөөд BEST-ийн тэтгэлэгт хөтөлбөрт шалгаран, 10 сая төгрөгийн санхүүжилт авч шаардлагатай тоног төхөөрөмжүүдээ худалдаж авснаар бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2 дахин нэмэгдүүлж, компани байгуулснаар борлуулалтын сувгаа өргөжүүлж, сүлжээ дэлгүүрүүд болон байгууллагуудад бүтээгдэхүүнээ борлуулж байна.





“ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН САНХҮҮЖИЛТИЙН ШИНЭ ГАРЦ,



Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилтээр Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх (BEST) хөтөлбөр нь Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой нэгдсэн форумыг зохион байгууллаа. Энэхүү форумгаар Засгийн газар, хувийн хэвшил, олон улсын хөгжлийн байгууллагуудын төлөөллүүдийн Монгол Улсын ХАА-н салбарыг хөгжүүлэх шинэлэг шийдлүүд, санхүүжилтийн загварыг хэрэгжүүлэхэд тулгарч

буй сорилт, боломжуудын талаарх стратегийн үзэл баримтлалыг нэгтгэлээ.

Тус форумыг нээн Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Ричард Буанган, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Дэд Сайд М.Ганхүлэг, Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал Л.Амар нар үг хэлэв. Тэд нээлтийн үгэндээ хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэн бэхжүүлэхэд түншлэл, хамтын ажиллагаа нэн чухал болохыг онцолж байв.



ШИЙДЭЛ” ФОРУМ

2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр

BEST



Элчин сайд Буанган хэлсэн үгэндээ:

“Монголын хөдөө аж ахуйн салбарт бордоо зэрэг нэн шаардлагатай бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдсан, зах зээлийн тодорхойгүй байдал зэрэг урьд өмнө байгаагүй сорилттой тулгарч байна,” гэдгийг онцлон дурдаад “АНУ-ын Засгийн газар эдийн засгийн тогтвортой, уян хатан өсөлтийг дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн олон үйл ажиллагааны хүрээнд Монгол түншүүдтэй хамтран ажилласаар ирсэн”

хэмээн илэрхийлсэн юм.

Форумын үеэр АНУ-ын USAID-ийн BEST хөтөлбөр, Монголын Банкны Холбоо, Банк Санхүүгийн Академийн хамтран гүйцэтгэсэн хөдөө аж ахуй эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээт байдлын судалгааны үр дүнг онцлон танилцуулав. Панел хэлэлцүүлгүүд нь хөдөө аж ахуйн гэрээт үйлдвэрлэлд суурилсан санхүүжилтийн шинэлэг стратеги, салбарын онцлог хэрэгцээнд нийцсэн санхүүжилтийн загваруудыг тохируулан нэвтрүүлэх, мөн арилжааны банкнуудад хөдөө аж ахуйн санхүүжилтэд зориулсан нэгж байгуулах боломж зэрэг сэдвийн хүрээнд өрнөлөө.








“ЭНТРЕПРЕНЕР ЭМЭГТЭЙЧҮҮД III:

ЭВ НЭГДЭЛД СУУРИЛСАН БИЗНЕСИЙН МАНЛАЙЛАЛ” ФОРУМ

BEST хөтөлбөрийн зүгээс BEST хөтөлбөрийн зүгээс Олон Улсын Эмэгтэйчүүдийн Эрхийг Хамгаалах өдрийг угтан харилцагч эмэгтэй бизнес эрхлэгч нартаа зориулан ЭНТРЕПРЕНЁР ЭМЭГТЭЙЧҮҮД форумыг гуравдах удаагаа **ЭВ НЭГДЭЛД СУУРИЛСАН БИЗНЕСИЙН МАНЛАЙЛАЛ** сэдвийн дор жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд сайн туршлагаа солилцох, харилцан суралцах боломж олгох замаар нийгмийн болон хамтын бизнесийн санаачилгууд, манлайллыг дэмжих зорилготойгоор зохион байгууллаа.



Форумын үер BEST хөтөлбөрийн харилцагч эмэгтэй жижиг дунд бизнесүүд нь өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний загвараа танилцуулжээ.



2023 оны 3 дугаар сарын 3-ны өдөр



BEST хөтөлбөрийн зүгээс энэ удаагийн форумд оролцогч нарт зориулан “Жижиг дунд бизнес дэх эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт судалгааны ажлын онцлох үр дүнг танилцуулсан. Мөн BEST хөтөлбөрийн харилцагч Зу Зу ХХК-ийг үүсгэн байгуулагч Н.Эрдэнэ, Монголын Экспорт, Кластерийн Сүлжээ ТББ-ын УЗ-ын дарга Н.Сарангуа, Дөрвөн Хүсэл ХХК-ийн ТУЗ-ын гишүүн Ц.Сумъяа, BEST хөтөлбөрийн Засаглал Хариуцсан Зохицуулагч П.Амармэнд зэрэг илтгэгч хүрэлцэн ирж, эмэгтэйчүүд эвлэлдэн нэгдэж хамтдаа хөгжих боломжуудын талаар илтгэл тавьж, менежментийн сайн туршлагуудыг хуваалцсан.

Форумд 120 орчим салбартаа манлайлагч жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүд оролцон хоорондоо эвлэлдэн нэгдэх, хамтран нийгэмдээ ээлтэй бизнесийг хөгжүүлэх, боломж, шийдлүүдийг хэлэлцэж сайн туршлагуудыг хуваалцсан.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨХҮҮДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАНА ГЭДЭГ ГАРЧГИЙГ ХАА-Н САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ТЕХНОЛОГИ, СТАНДАРТЫГ САЙЖРУУЛАХАД МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХҮҮДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАА

BEST хөтөлбөрийн хийсэн ХАА-н суурь судалгаанд хамрагдсан ЖДБ нарын 94,6% нь ямар нэг чанарын менежментийн тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлээгүй, мөн Төр, засгийн бодлого шийдвэр хүнсний хангамж, аюулгүй байдлыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч байгаа, ХАА-н бүтээгдэхүүний чанарыг хамгаалах, баталгаажуулах үйл ажиллагаа нь доголдолтой байдгаас зах зээлд бүтээгдэхүүнийхээ үнэ цэнийг нэмэгдүүлж чадахгүй байгаа зэрэг нөхцөл байдалтай уялдуулан ХХАА-н ЖДБ нарт өгөх Үндэсний Зөвлөх байгууллагуудын зөвлөх үйлчилгээг чанарын удирдлагын тогтолцоог бий болгох чадавхийг нэмэгдүүлэхэд чиглүүлж ажиллав. Эдгээр зөвлөх үйлчилгээнд нийт 1093 харилцагч хамрагдсан бөгөөд тоног төхөөрөмжөө шинэчлэх, ХААЗД, ҮЗД, ЭАЗД хэвшүүлэх, ХААЗД болон НАССР гэрчилгээ авах зэрэг олон үр дүнг гаргасан байна.



СҮҮ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЗОХИСТОЙ ДАДАЛ, СТАНДАРТЫГ САЙЖРУУЛАХ

СҮҮ	МАХ	ХҮНСНИЙ НОГОО
Зөвлөх байгууллагууд:	Монголын Хүнсчдийн Холбоо	Технологийн Дээд Сургууль
Хамрагдсан ЖДБ:	290	
Зөвлөх үйлчилгээний сэдэв	Сүү боловсруулах үйлдвэрийн Эрүүл ахуйн ба Үйлдвэрлэлийн зохистой дадал, ISO 22000:2018, НАССР	Сүү, сүүн бүтээгдэхүүнийг хадгалах, зах зээлд нийлүүлэх үе шатанд мөрдөх стандарт шаардлагууд, арга технологиуд
Зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулагдаж хэвлэгдсэн гарын авлага	Сүү, сүүн бүтээгдэхүүнийг хадгалах, зах зээлд нийлүүлэх үе шатанд мөрдөх стандарт шаардлагууд, арга технологиуд	
Үр дүн:	Сүү боловсруулах 2 үйлдвэрт нийцлийн шинжилгээ хийж, чанарын удирдлагын тогтолцоог бий болгох үндэс суурийг тавив.	



МАХ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО, СТАНДАРТЫГ САЙЖРУУЛАХ

СҮҮ	МАХ	ХҮНСНИЙ НОГОО
Зөвлөх байгууллагууд:	Праймер ХХК	
Хамрагдсан ЖДБ:	178	
Зөвлөх үйлчилгээний сэдэв	Мах боловсруулах үйлдвэрийн чанарын удирдлагын тогтолцоо, хүнсний аюулгүй байдлын олон улсын стандарт хэрэгжүүлэх шаардлага	
	Мах, махан бүтээгдэхүүнийг хадгалах, зах зээлд нийлүүлэх үе шатанд мөрдөх стандарт шаардлагууд, арга технологиуд	
	Мах үйлдвэрлэлийн гарын авлага	
Зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулагдаж хэвлэгдсэн гарын авлага:	Махны үйлдвэрийн дотоод лабораторийн зохистой дадал	
	Мах, махан бүтээгдэхүүнийг хадгалах, зах зээлд нийлүүлэх үе шатанд мөрдөх стандарт шаардлагууд, урт хугацаанд хадгалах арга технологиуд	
Үр дүн:	Мах боловсруулах 4 үйлдвэрт нийцлийн шинжилгээ хийж, чанарын удирдлагын тогтолцоог бий болгох сайжруулах зөвлөмжийг өгч ажиллав.	
	7 Мах боловсруулах үйлдвэр НАССР гэрчилгээ авав.	

ХҮЛЭМЖИЙН АЖ АХУЙН ЗОХИСТОЙ ДАДАЛ, ХҮНСНИЙ НОГООНЫ ХАДГАЛАЛТЫН СТАНДАРТЫГ САЙЖРУУЛАХ

СҮҮ	МАХ	ХҮНСНИЙ НОГОО
Зөвлөх байгууллагууд:	Монголын Хүлэмжийн Аж Ахуй Эрхлэгчдийн Холбоо	
	Монголын Хөдөөг Шинэчлэхийн төлөө Фермерүүдийн Холбоо	
	Ногоон гариг-Ногоон Ирээдүй ТББ	
Хамрагдсан ЖДБ:	625	
Зөвлөх үйлчилгээний сэдэв	Хүлэмжийн зохистой дадал	
	Хүлэмжийн таримал ургуулах агротехник	
	Хүнсний ногооны агуулах зоорь, хадгалалтын стандарт шаардлагууд	
Зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулагдаж хэвлэгдсэн гарын авлага:	Хүлэмжийн зохистой дадал	
	Хүлэмжийн зохистой дадалын бүртгэлийн дэвтэр	
	Хүнсний ногооны агуулах зоорь, хадгалалтын стандарт шаардлагууд	
Үр дүн:	Хүнсний ногоо боловсруулах технологи	
	62 аж ахуй Хөдөө аж ахуйн зохистой дадал хэвшүүлснээ баталгаажуулж, гэрчилгээ авав.	

ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ

ЖДБ-үүдийн мэдлэг, туршлага хуваалцах нөхцөлийг хангах, бизнес хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгох боломжийг нэмэгдүүлэх үндсэн зорилгын хүрээнд тайлант хугацаанд бизнесийг хөгжүүлэх Scale up, Green Lab, 5X, Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, ХАА-н ЖДБ эрхлэгчдийг дэмжих зэрэг Хурдасгуур хөтөлбөрүүдэд хамрагдсан ЖДБ нар, мөн Захирлуудын клубын гишүүн ЖДБ эрхлэгч нарын 175 хүн оролцсон 8 удаагийн сургалтын аялал зохион байгуулав.

Сургалтын аяллын хүрээнд ажлын байрны зохион байгуулалт, сайн засаглал, чанарын удирдлага, хяналтын тогтолцооны талаарх мэдлэг, туршлагаа хуваалцаж, бизнес хооронд түүхий эд бүтээгдэхүүн нийлүүлэх, хог хаягдлыг бууруулах, нөөцийг хамтран эзэмших зэрэг стратегийн түншлэл, хамтран ажиллах бизнес саналуудыг солилцсон байна.

8 УДААГИЙН СУРГАЛТЫН АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАВ



175
ХҮН
ОРОЛЦСОН



**ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН
САЛБАРЫН
ЖДБ,
ХОРШООД**

**ЭМЭГТЭЙ БИЗНЕС
ЭРХЛЭГЧДИЙГ
ДЭМЖИХ, ХАА-Н
ЖДБ ЭРХЛЭГЧДИЙГ
ДЭМЖИХ**



ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА

ЭЛЧИН АЙЛЧЛАЛ

STUDY TOUR



BEST

ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

АНУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙД РИЧАРД Л. БУАНГАН BEST ХӨТӨЛБӨРИЙН ХАРИЛЦАГЧИЙН БИЗНЕСЭЭР ЗОЧЛОВ

АНУ-аас Монгол улсад суугаа Элчин сайд **Ричард Л.Буанган**, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Хөгжлийн ахлах зөвлөх **Томас Крехан** нар Хөвсгөл аймагт айлчлах үеэрээ BEST хөтөлбөрийн харилцагч **Э.Аръяабазарын**

Arya Cafe-гаар зочилсон. Arya Café нь хөдөө орон нутгийн залуучуудад өөрсдийн чадавхаа таньж мэдэх, өвөрмөц байдлаа ухамсарлах, эерэг сэтгэлгээний талаар суралцах орчныг бүрдүүлж буй онцгой бизнес юм.



ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА

BEST хөтөлбөрийн Улаанбаатар болон орон нутгийн 12 салбар нь ЖДҮГ, НЖДҮДТ болон АЗДТГ, ХХААГ-тай хамтран Цагаан сар болон Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдааг жил бүр уламжлал болгон зохион байгуулсаар байна. Энэхүү үйл ажиллагаагаар дамжуулан харилцагч нарын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, мөн хөтөлбөрийн үйл ажиллагааны үр дүнг олон нийтэд таниулахаар зорьдог. Ингээд 2023 онд **18** удаагийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулснаар **497** харилцагчийг **1,5** тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаа.



18 удаагийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан



497 харилцагчийг 1,5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлчилгээг



ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА

ЭЛЧИН АЙЛЧЛАЛ

STUDY TOUR

Цагаан сар



BEST

ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Намрын ногоон өдрүүд



ЗАХ ЗЭЭЛД НИЙЛҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭН АЖИЛЛАА

SME day



ДИЖИТАЛ ШИЙДЭЛ ХӨГЖҮҮЛЭЛТ



BEST хөтөлбөр нь Улаанбаатар болон 12 аймаг, түүний бүх сумдыг хамруулан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хэрэглэгч, харилцагч бүрд хүрч, хүртээмжтэй ажиллах, оролцоог хангуулахад дараах дижитал шийдлүүд томоохон хувь нэмрийг оруулж байна.

ГРАНТ ПРОГРАММ

Тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулах систем

BEST хөтөлбөрийн Зорилт-5-ын үйл ажиллагаанд 3 төрлийн гадаад программууд ашиглаж байсан бөгөөд дата мэдээллүүд нь өөр эх үүсвэрүүд дээр хадгалагдаж, олон программ дээр бүртгэгдэж байв. Тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын системийг хөгжүүлснээр нэг платформуос мэдээллүүдийг хэмжих, үнэлэх, хянах боломжтой технологийн цогц шийдэл бүхий системийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлээд байна. Ингэснээр харилцагчийн мэдээллийн хадгалалт, нууцлалын төвшин сайжирч, зайнаас сонгон шалгаруулалтын явцыг удирдах, хянах, зохион байгуулах боломжтой боллоо.



BIZGUIDE

Хөгжлийн Шийдэл ТББ нь онлайн сургалтын систем болох www.learning.bizguide.mn платформыг BEST хөтөлбөрийн харилцагч нарт онлайн орчинд суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор ашиглалтад оруулсан. Онлайн сургалтын платформыг бүхий л төрлийн төхөөрөмжөөс хандан суралцах боломжтой бөгөөд гар утасны Bizguide learning аппликэйшн ашиглан суралцах боломжтой юм. 2023 оны байдлаар **16** сургалт **67** дэд сэдвийн хүрээнд онлайн хичээл сургалтын системээр дамжуулан хүргэгдэж байна.

Тоон үзүүлэлтүүд:

2023 оны үр дүн:

Сургалтад хамрагдсан харилцагчийн тоо: **505**

Нийт хичээл үзсэн цаг: **28573**

Сургалтыг бүрэн дуусгасан харилцагч: **110**



BIZGUIDE



GET IT ON
Google Play

Available on the
App Store



ЗЭЭЛИЙН ЗӨВЛӨГӨӨ АВАХ ОНЛАЙН ПЛАТФОРМ

Хөтөлбөрийн хүрээнд ЖДҮХС-аас зээл авахаар төлөвлөж буй харилцагчдад зээлийн зөвлөгөө өгч ажилласан бөгөөд зөвлөгөө авах боломжийг нэмэгдүүлэх үүднээс ЖДҮГ-н зээлийн хүсэлт хүлээн авч буй цахим веб болох www.sme.gov.mn веб дээр “Зөвлөгөө авах” гэсэн онлайн хүсэлт илгээх хэсгийг байршуулсан. Энэ нь ЖДҮХС-нд зээлд материал илгээх явцад зээлтэй холбоотой зөвлөгөө авах шаардлага гарвал BEST хөтөлбөрт хүсэлтээ илгээн холбогдох боломжийг олгосноороо онцлог байлаа. Зөвлөгөө авах хэсгээр дамжуулан 13 салбарын хэмжээнд нийт **174 бизнес эрхлэгч** BEST хөтөлбөрөөс зөвлөгөө авсан бөгөөд зөвлөгөө авсан харилцагчдын **60** гаруй хувь нь ЖДҮХС-аас зээлээ амжилттай авч чадсан байна.

ДУНД ШАТНЫ ҮНЭЛГЭЭ АМЖИЛТТАЙ ХИЙГДЛЭЭ

2023 онд **IRIM** судалгааны хүрээлэн нь BEST хөтөлбөрийн дунд шатны үнэлгээг амжилттай хийж гүйцэтгэлээ. Уг үнэлгээний гол зорилго нь хөтөлбөрийн 2021 болон 2022 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудын гүйцэтгэлийг үнэлж, цаашид сайжруулах боломжтой, шаардлагатай талбаруудыг тодорхойлсон.

АЖИЛТАН ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2023 оны 3-р сард АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Филиппин дэх төлөөлөгчийн газрын Хуулийн Суурин ажилтан (RLO) **Брэндон Эдвард Миллер** BEST хөтөлбөрийн оффист зочилж, ёс зүйн чиглэлээр сургалт явуулав. Сургалтаар ёс зүйн зарчим, бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчил, хувийн нууцын тухай ойлголт зэрэг сэдвүүдийг хөндсөн.
- 2023 оны 11-р сард өдөр Бангкок дахь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Ерөнхий байцаагчийн газрын (OIG) Тусгай ажилтан **Кристофер Нордин**, Эрүүгийн мөрдөн байцаагч **Майкл Парк** нар BEST хөтөлбөрийн ажилтнуудад OIG-ийн үйл ажиллагаа, АНУ-аас санхүүжүүлдэг хөтөлбөрүүд залилан, авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд Хөгжлийн Шийдэл ТББ болон түүний ажилтнуудын гүйцэтгэх үүргийн талаар мэдээлэл өгөх сургалт явууллаа. Мөн Вашингтон хот дахь USAID OIG-ийн Туслах тусгай агент **Дамиен Таймс** мөрдөн байцаалт, шалгалтын үйл явцын талаар ойлголт өгөх үүднээс өөрт тохиолдсон залилангийн түүхүүдээс хуваалцсан.
- 2023 онд ажилтнуудыг хөгжүүлэх ажлын хүрээнд BEST хөтөлбөрийн 5 ажилтан ХБНГУ-ын Берлин хотноо жил бүр зохион байгуулагддаг “**Хөдөө Аж Ахуйн Ногоон 7 хоног**” экспод оролцож, ХАА-н бизнесүүдийг хэрхэн дэмжих тухай сургалтад хамрагдсан.
- BEST хөтөлбөрийн 5 ажилтан Сингапур улсад төслийн менежментийн гэрчилгээ олгох 5 хоногийн сургалтад хамрагдсан. Энэхүү сургалт нь хөтөлбөрийн хэрэгжилтийн туршид төслийн менежментийн мэдлэг, практикийг сайжруулахад чиглэгдсэн байсан.
- 2023 онд Хөгжлийн Шийдэл ТББ-ын нийт ажилтнуудад зориулж 2 удаагийн “**Pause and Reflect**” үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус “Pause and Reflect” үйл ажиллагаануудын үеэр ажилтнуудын хувь хүний ур чадварыг хөгжүүлэх зорилгоор “Цэгцтэй сэтгэх арга” болон “Процессыг схемчлэн, сайжруулах аргачлал” сургалтуудад хамруулснаар зөвлөх үйлчилгээний чадвараа сайжруулав.



ИРГЭНИЙ ТАНХИМ

“ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ
АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ
ДЭМЖИХ ТӨСӨЛ”

2018-2024 он

ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

2018-2024 он

Зорилго:

ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ, ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ТОГТВОРТОЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХАА-Н БИЗНЕСҮҮДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ОЮУТОЛГОЙ ХХК-Н САНХҮҮЖИЛТТЭЙГЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСЛҮҮДЭД ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ.

Үндсэн үйл ажиллагаа:

Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчид, Оюу Толгой ХХК, Ханбогд сумын Засаг

- Даргын Тамгын Газар хоорондын хамтарсан Гурван Талт Зөвлөлөөс хэрэгжүүлж буй хөдөө аж ахуйг дэмжих чиглэлийн төслүүдэд зөвлөгөө өгөх.

Ханбогд сумын МАА-н салбарыг хөгжүүлэх 10 жилийн төлөвлөгөөний хүрээнд

- Оюутолгой ХХК-аас хэрэгжүүлж буй төслүүдэд зөвлөгөө өгөх.

Ханбогд сумын нийт малчид, анхан шатны хоршоод, дундын хоршоодын

- хэрэгжүүлж буй төслүүдэд төлөвлөлт, эзэмшил, ашиглалт, үр ашгийг гишүүд малчдад, орон нутагт тэгш хуваарилах чиглэлээр зөвлөгөө өгөх. Үүнд: Мал төхөөрөх үйлдвэр, Мал аж ахуйн бүтээгдэхүүн борлуулах худалдааны төв, Малын гаралтай түүхий эдийн худалдааны төв байгуулах төслүүд багтана.

Үр дүн:

2023 онд Ханбогд сумын баг бүрийн анхан шатны хоршоод нэгдэж "Галбын говийн Торгон сүрэг хоршоо" байгуулсан.

2023 онд Ханбогд сумын хэмжээнд АДТ-үүдэд нийт 1 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгоход туслалцаа үзүүлсэн.

МАЛЧДЫН ӨМЧЛӨЛ БҮХИЙ МАЛ НЯДАЛГААНЫ ҮЙЛДВЭР

Монголд анх удаа нэг сумын бүх малчид өөрийн гэсэн махны үйлдвэртэй болно. Ханбогд сумын нийт малчдын өмчлөл бүхий мал нядалгааны үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил эхлэхэд бэлэн боллоо.

Ханбогд сумын мал аж ахуйн бизнесийг хөгжүүлэх, ХАА-н бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой Мал нядалгааны үйлдвэрийн төслийг анхны санаачилгаас нь эхлэн хөгжүүлж олон улсын жишигт нийцсэн, малчдын өмчлөл бүхий үйлдвэр барих, хоршоогоор дамжуулан малчдын орлогыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдлээ.

Гурван талт зөвлөлийн гэрээний хавсралтад орсон мал нядалгааны зам барих ажлыг хариуцсан малчдын ажлын хэсэгтэй хамтарч ажиллаж эхэлсэн.

Гэрээний хавсралтад заасан нэг өгүүлбэрийг гурван талт зөвлөлийн бүх оролцогч талууд хэрхэн ойлгож байгааг тодруулах ярилцлагууд хийсэн.

Улмаар Ханбогд сумын МАА салбар болон махны үйлдвэрлэлийн өнөөгийн болон ирээдүйн нөхцөл байдлын судалгаа, урьдчилсан хэрэгжих боломжийн судалгаа, хэрэгжих боломжийн судалгааг боловсруулсан. Ханбогд сумын мал

нядалгааны цехийн төслийг Өмнөговь аймгийн зүүн бүсийн сумдын махны үйлдвэр болгон бизнес төсөл боловсруулж, хэрэгжүүлэх бизнес загвар, засаглалын загварыг малчдад хамгийн ашигтай хувилбараар санал болгосон.

Энэхүү үйлдвэр нь жилдээ 3,600 толгой бод, 36,000 бог нядлах ба агуулах нэг удаадаа 100 тн хадгалах хүчин чадалтай байна. Бизнес загварын хувьд малчид өөрийн үйлдвэртээ өөрийн малыг нядлан, махыг нь ангилж, боловсруулан зах зээлд

борлуулж, үйлдвэрийн ашгаа малчид өөрсдөө авна. Засаглалын хувьд малчид хоршоогоор дамжуулан махны үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг эзэмшиж, гүйцэтгэх удирдлагыг нь томилно.

Энэ нь Монгол улсын 330 сумдад хэрэгжүүлж, малчдыг махны үйлдвэртэй болгосноор малчдын орлого, сумын дотоодын нийт бүтээгдэхүүн, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх жишиг загвар болсон.



Батлагдсан мал нядлах үйлдвэрийн план



Үүнд:

- Мал нядлах цехийг нөхцөл байдалтай уялдуулан Мал нядалгааны үйлдвэр болгон өргөжүүлж төлөвлөсөн.
- Мал нядлах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулж үйл ажиллагаа, үйлдвэрлэл, технологи, үр ашгийн хувьд хэрэгжих боломжтойг баталгаажуулсан.
- Мал нядалгааны үйлдвэрийн суманд үзүүлэх “Байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан” үнэлгээ хийлгэсэн.
- Сумын нийт малчдын нэгдсэн хоршоо байгуулах ажлыг чиглүүлж, бүх малчдаар явж танилцуулан, багийн хурлаар нь шийдвэр гаргуулан, багуудын хоршоог нэгтгэсэн сумын хэмжээний дундын хоршоо нь махны үйлдвэрийн менежментийг хариуцан ажиллахаар боллоо. Нийт 380 малчдыг хамруулсан “Галбын Говийн Торгон сүрэг” дундын хоршоо байгуулагдсан.

ТЭЗҮ-н хүрээнд Мал нядлах үйлдвэрийн зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж Улсын Экспертизээр батлуулж үйлдвэр барихад бэлэн болсон.

НЭГ СУМ – НЭГ ХОРШОО ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Жижиг Дунд Үйлдвэрийн Газар, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Өмнөговь аймгийн Ханбогд сумын ЗДТГ, Оюу толгой ХХК болон Хөгжлийн шийдэл ТББ зэрэг оролцогч талууд хамтран

“Нэг Сум - Нэг Хоршоо” зөвлөгөөнийг 2023 оны 4-р сарын 25-ны өдөр Өмнөговь аймгийн Ханбогд суманд амжилттай зохион байгууллаа.



Тус зөвлөгөөн нь хоршооны тухай хуулийн шинэчлэн батлагдсантай холбоотой төрөөс хоршооны талаар баримталж буй бодлогыг сурталчлах, Нэг сум – Нэг хоршоо загвар бодлогын хүрээнд төр хоршооллын хамтын ажиллагааг өргөжүүлэх, тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, гишүүд, малчдын амьдрал, хүрээлэн буй орчинд гарах эерэг өөрчлөлтүүдийг таниулах зорилгоор зохион байгуулсан бөгөөд зөвлөгөөнд Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй хоршоод болон холбогдох оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн 180 гаруй хүн оролцсон.

Нэг сум – Нэг хоршоо зөвлөгөөний хүрээнд ЖДҮГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга А.Гэрэлзаяа “Төрөөс хоршооны талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт”, Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ш.Бат-Эрдэнэ “Хоршооны хөгжлийг дэмжих жилийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, цаашдын бодлого төлөвлөлт”, ХАА-н биржийн арилжаа зах зээл хөгжүүлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Оюунбилэг “Түүхий эдийг Хөдөө аж ахуйн биржээр арилжих боломж, үр ашиг”, эдийн засагч Д.Жаргалсайхан “Шинэ хоршоо

хөдөлгөөн” сэдвээр тус тус илтгэл тавьж мэдээлэл хийлээ. Мөн Говь-Алтай аймгийн Дарви сумын “Буян-Ундрал” хоршооны дарга Д.Эрдэнэбат, “Цэвэр хөрсний шим” дундын хоршооны дарга Х.Доржсүрэн, Төв аймгийн “Өндөр ширээт” хоршооны дарга Ц.Оюун нар тус зөвлөгөөнд оролцож өөрсдийн

сайн туршлага, асуудал бэрхшээл, амжилт ололтоо хуваалцсан.

Уг зөвлөгөөний үйл ажиллагаа нь цаг үеэ олсон

онцлох ажил болсон бөгөөд Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчдын байгуулсан анхан шатны хоршоодын тэргүүлэгчид болон байгуулахаар ажиллаж байгаа дундын хоршооны ажлын хэсгийн төлөөллүүд идэвх санаачилгатай оролцсон. Учир нь малчдын дундын хоршоог үүсгэн байгуулах процесстэй холбоотой тулгарсан

бэрхшээлүүдийн талаар зөвлөгөөнд оролцож буй холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудын төлөөллүүдэд танилцуулж, гарц гаргалгаа олох чөлөөт хэлэлцүүлгийг өрнүүлсэн. Ингэснээр дундын хоршоог үүсгэн байгуулахтай холбоотой дэмжлэгийг Жижиг дунд үйлдвэрийн газар, Монголын Хөдөө Аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны зүгээс үзүүлэхээр болсон. Мөн энэхүү дундын хоршоо үүсгэн байгуулах төсөл нь Монгол Улсын Засгийн Газрын зүгээс авч хэрэгжүүлж буй хоршооны салбарын бодлого, хөтөлбөрүүдийн зорилго, чиглэлтэй нийцтэй байгаа бөгөөд цаашид жишиг хоршоо болон хөгжих боломжтой болохыг Жижиг дунд үйлдвэрийн газрын холбогдох төлөөллүүд онцолж, хууль эрх зүйн болон бодлого хөтөлбөрөөр дэмжин ажиллах боломжтой болохоо илэрхийлсэн нь талархуштай байсан.



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЖДБ – ИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА

Оюу Толгой ХХК-н Орон нутгийн харилцааны хэлтэс болон Хөгжлийн Шийдэл ТББ хамтын ажиллагааны хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчдын хоршоо, Жижиг дунд бизнес эрхлэгчид, Гарааны бизнес эрхлэх сонирхолтой залуусыг бизнесийн мэдлэг туршлагыг нэмэгдүүлэх, шаардлагатай ур чадваруудыг олгох, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой цогц сургалтын хөтөлбөрийг 2023 оны 5-р сарын 30-ны өдрөөс эхлэн амжилттай хэрэгжүүлж байна.

Одоогийн байдлаар нийт **8** удаагийн сургалтыг дараах сэдвүүдийн хүрээнд амжилттай зохион байгуулж, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт **130** орчим жижиг дунд бизнес эрхлэгч, хоршоодын төлөөллийг хамруулаад байна. Үүнд:

1. Стратегид суурилсан бизнес загварын өөрчлөлт
2. Стратеги төлөвлөгөө ба компанийн засаглал
3. Санхүүгийн тайлагнал ба Санхүүжилтийн боломж
4. Сошиал медиа хөгжүүлэлт
5. Ногоон болон нийгмийн бизнес эрхлэлт
6. Компанийн засаглал ба хувьцаа эзэмшигчид
7. Бизнес төлөвлөлт
8. Нэгж бүтээгдэхүүний өртөг ба Хугарлын цэгийн шинжилгээ

Хөгжлийн Шийдэл ТББ-н хувь нь Оюу толгой ХХК-н Орон нутгийн харилцааны хэлтэстэй хамтран Ханбогд сумын малчдын хоршоодыг чадавхжуулах, хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байгаа бөгөөд энэ удаагийн хамтарсан хөтөлбөрийн үр дүнд орон нутгийн бусад бизнес эрхлэгчид шаардлагатай мэдлэг ур чадварыг эзэмшиж хөгжлийн дараагийн шатанд гарах боломж нь нэмэгдэнэ гэж харж байна. Мөн энэ хөтөлбөрт бүрэн хамрагдсанаар Ханбогд сумын хэмжээнд шинэ эрэлт хэрэгцээнд суурилсан бизнесүүд бий болохын зэрэгцээ бизнесийн мэдлэг ур чадвар нэмэгдэж, борлуулалтын орлого, орон нутгийн эдийн засгийн байдалд хувь нэмэр болно гэж харж байна.

Цаашид ч хөтөлбөрийн үйл ажиллагаа үргэлжлэн зохион байгуулагдах бөгөөд Ханбогд сумын бизнес эрхлэгч хэн бүхэнд энэ хөтөлбөр нь нээлттэй байх болно.



“МАЛЧДЫН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨР

2018-2024 он

Зорилго:

Оюу Толгой ХХК-ны Орон Нутгийн Харилцааны хэлтэстэй хамтран уурхайн нөлөөлөлд өртсөн малчдын амьжиргааг дэмжих бизнесийн санаачилгуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Тоон үр дүн:

	Зохион/б тоо:	Оролцогчийн тоо:
Малчдад чиглэсэн сургалт, уулзалтын тоо	21	1548
Бусад сургалт, уулзалтын тоо	38	496
Зөвлөх үйлчилгээний тоо	51	493

Үндсэн үйл ажиллагаа:

1. Малчдын бизнес санааг хөгжүүлэх,
2. Малчдын бизнес санааны хэрэгжих боломжийн судалгааг хийх,
3. Малчдын бизнес санааг хэрэгжүүлэх бизнес загварыг тодорхойлох,
4. Малчдын бизнес санааг хэрэгжүүлэх төслийг боловсруулах,
5. Бизнес төслийг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийн засаглалын загварыг тодорхойлох,
6. Аж ахуй нэгжийн засаглалын бүтэц тодорхойлох, бүтцийн өөрчлөлт, дүрэм журмын өөрчлөлт хийхэд зөвлөгөө өгөх,
7. Бизнес төслийг хэрэгжүүлэхэд засаглал, менежментийн зөвлөх үйлчилгээ,
8. Бизнесийн стратеги төлөвлөгөөг боловсруулах,
9. Бизнес төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх

Амжилтын түүх

Гавилууд Гурван Шаваг ХХК

Гавилууд Гурван Шаваг ХХК-г үүсгэн байгуулагч, гүйцэтгэх Х.Рэнцэн нь 2020 онд өрхийн аж ахуйгаар цөөн тоотой гахайг үржүүлж эхэлсэн. Өрхийн бизнесээ өргөжүүлэхэд гахайн фермийн үйл ажиллагаа, гахай маллагааны технологи, гахайн байрны стандарт зэргийг сайтар тооцсон бизнес төсөл шаардлагатай болсон. Мөн энэхүү бизнес төсөлдөө хөрөнгө оруулалт татах, төслийг санхүүжүүлэх хэрэгцээ шаардлага гарсан. Энэ үед Хөгжлийн Шийдэл ТББ-ын Ханбогд салбарт хандаж гахайн аж ахуйн стандарт, гахайн маллагаа, тухайн төслийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тус төслийг амжилттай хэрэгжүүлэх боломжтой засаглал, менежментийн тогтолцоотой бүрэн хэмжээний төсөлтэй болсноор хөрөнгө оруулалт татаж, үндсэн 10 мэжтэй, эргэлтийн 100 гахайтай аж ахуйг байгуулсан.



Тус төсөл нь Ханбогд сумын хоолны газар, ресторанууд, уул уурхайн компаниудад сайн чанарын гахайн махыг үйлдвэрийн аргаар бэлтгэн нийлүүлэх зорилготой бөгөөд жилдээ 10 тонн махыг зах зээлд нийлүүлэх боломжтой.



A stylized illustration in a pinkish-red hue. It depicts several figures engaged in planting trees. In the upper left, a figure in a red hat and orange tunic carries a large green tree. In the upper right, a figure in a green suit carries a tree. In the lower right, a figure in a red suit is bent over, planting a tree. The background features jagged mountain peaks. The text is overlaid in the center-left.

“ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН ШИЛЖИЛТ” SOGE ТӨСӨЛ

2022-2025 он

МОНГОЛЫН ХАМШИГТ НЭРВЭГДСЭН ИРГЭДЭД
ЭНДЭГШЛЭГЭЙГ УУР АМЬСГАЛЫН

“ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН ШИЛЖИЛТ” SOGE ТӨСӨЛ

2022-2025 он

Зорилго:

Европын Холбооны Switch Asia хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй тойрог эдийн засагт шилжих, улмаар ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготойгоор Пийпл ин Нийд ОУТББ, Каритас Чех Репаблук ОУТББ, ТоС холбоо болон Хөгжлийн Шийдэл ТББ хамтран Улаанбаатар хот, Эрдэнэт, Сэлэнгэ аймгуудад Эдийн Засгийн Ногоон шилжилт төслийг хэрэгжүүлж байна.

Үндсэн үйл ажиллагаа:

Төслийн хүрээнд Монгол Улсын хөдөө аж ахуйн хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын бичил, жижиг, дунд үйлдвэрлэгч, борлуулагчдыг дадал, зан төлөвөө өөрчлөхөд шаардлагатай мэдээлэл, аргачлалаар хангах, улмаар зах зээлд суурилсан эко шошгыг нэвтрүүлж, ногоон санхүүжилтийн эх үүсвэртэй болох, улмаар “Тойрог эдийн засаг”-т шилжихэд нь дэмжлэг үзүүлнэ.

Үр дүн:

Төслийн үр дүнд бичил, жижиг, дунд үйлдвэрлэл болон жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчид баримтлах эко шошгын нэгдсэн стандарт боловсруулж, эко шошгожуулалтын онлайн платформыг шинээр бий болгох, улмаар эко шошгожуулах үйл явцыг санхүүгийн дижитал хэрэгслүүдтэй холбох ба одоогоор энэ талын судалгааны ажлуудыг хийгээд байна.

ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН ШИЛЖИЛТ” SOGE ТӨСӨЛ



Үйл ажиллагаа	Зохион/6 тоо:	Оролцогчийн тоо:	Тайлбар
Сургалт 1: СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ	1	50	SOGE төслийн зорилгын хүрээнд Бичил жижиг дунд үйлдвэрлэл, Жижиглэнгийн худалдаа эрхлэгчид, Бизнесийн холбоодод тогтвортой бизнесийн үйл ажиллагаа, ногоон стратеги болон тойрог эдийн засгийн талаар шаардлагатай мэдлэгүүдийг олгох зөвлөх үйлчилгээ үзүүлэх сургагч багш нарыг бэлтгэх сургалт 2023 оны 8 сарын 8-11нд Корпорейт зочид буудлын сургалтын танхимд зохион байгуулагдсан. Энэхүү сургалтын үр дүнд Улаанбаатар, Эрдэнэт, Сэлэнгэ аймагт нийт 46 тойрог эдийн засгийн сургагч багш нар бэлтгэгдэн цаашид БЖДБ-үүдийг сургаж хөгжүүлэх юм.
Сургалт 2: МЕНТОР БЭЛДЭХ СУРГАЛТ	1	30	SOGE төслийн хоёрдугаар зорилтын хүрээнд хүнс, ус, ундааны салбарын БЖДҮ-үүдэд менторингийн үйлчилгээ үзүүлэх, ментор болох сонирхолтой, салбарын өндөр мэдлэг, туршлагатай 20 мэргэжилтнийг бэлдэх сургалт 2024 оны 1 сарын 15нд Корпорейт зочид буудалд зохион байгуулагдсан. Эдгээр менторууд цаашид БЖДБ-үүдэд эко шошгожуулахад менторинг үзүүлж ажиллах юм.
Сургалт 3: БЖДҮЭ-ДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ХУРДАСГУУР ХӨТӨЛБӨР	3	105	Эдийн засгийн ногоон шилжилт төслийн хүрээнд БЖДҮЭ болон жижиглэн худалдаа эрхлэгчдийг тойрог эдийн засгийн чиглэлээр чадавхжуулах Хурдасгуур хөтөлбөрийн сургалтыг нийт 30 удаа зохион байгуулахаас, одоогоор 3 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулаад байна. (Эрдэнэт-2, Сэлэнгэ-1) БЖДҮЭ болон жижиглэн худалдаа эрхлэгчдийг ногоон бизнес бий болгох, улмаар ногоон зээлтэй холбох үйл ажиллагаа цаашид хийгдэх юм.
Уулзалт 1: SOGE ТӨСЛИЙН ЭРДЭНЭТ САЛБАРЫН НЭЭЛТ	1	35	Эдийн Засгийн Ногоон Шилжилт төсөл 2022-2025 онд Орхон аймагт хэрэгжих болсонтой холбоотой Орхон аймгийн төслийн хамтрагч байгууллагууд ЗДТГ, ХХААГ, МСҮТ, Хүнс Үйлдвэрлэгчдийн Холбооны тэргүүн зэрэг төлөөллүүдийг оролцуулан 2023 оны 3 сарын 21-д Төслийн танилцуулах уулзалтыг зохион байгуулж, төслийн зорилго, зорилт, цаашид хэрхэн хэрэгжих талаар танилцуулж, санал солилцсон юм. Энэ уг төслийн амжилттай явуулахад бодлогын дэмжлэг үзүүлэх юм.
Уулзалт 2: SOGE ТӨСЛИЙН СЭЛЭНГЭ САЛБАРЫН НЭЭЛТ	1	50	Эдийн Засгийн Ногоон Шилжилт төсөл 2022-2025 онд Сэлэнгэ аймагт хэрэгжих болсонтой холбоотой Сэлэнгэ аймгийн төслийн хамтрагч байгууллагууд ЗДТГ, МСҮТ, Хүнс Үйлдвэрлэгчдийн Холбооны тэргүүн зэрэг төлөөллүүдийг оролцуулан 2023 оны 10 сарын 4-нд Төслийн танилцуулах уулзалтыг зохион байгуулж, төслийн зорилго, зорилт, цаашид хэрхэн хэрэгжих талаар танилцуулж, санал солилцсон.



СЭЛЭНГЭ АЙМАГТ ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН ШИЛЖИЛТ ТӨСЛИЙН АЛБАН ЁСНЫ НЭЭЛТ

Эдийн Засгийн Ногоог Шилжилт төслийн нээлт болон танилцуулах уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд зохион байгуулав. Нээлтийн үйл ажиллагаанд орон нутгийн Төрийн болон ТББ, Аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл 55 хүн оролцсон бөгөөд уулзалтыг нээж, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Засаг дарга Д.Пүрэвдорж үг хэллээ. Мөн төслийн багийнхан төслийн

танилцуулга, төслийн зорилго, хүлээгдэж буй үр дүн, дараагийн үйл ажиллагаа болох Хурдасгуур хөтөлбөрийн төлөвлөгөөний талаар танилцуулга хийлээ. Мөн тус уулзалтын үеэр Сэлэнгэ аймгаас бэлтгэгдсэн сургагч багш “Эдийн засаг ба түүний үр нөлөө” сэдвээр танилцуулга хийлээ. Төслийн нээлтийн үйл ажиллагааны дараа төслийн багийнхан орон нутгийн органик цай үйлдвэрлэдэг “ҮЖЭЭД ХХК”-ны үйл ажиллагаатай танилцлаа.



ТЭЗ БА НОГООН БИЗНЕСИЙН ЧИГЛЭЛД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ БЖДБЭ-ИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Төслийн зорилго: БЖДБЭ нарын чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн боловсруулж, хэрэгжүүлэх замаар БОАЖЯ-ны ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газарт тойрог эдийн засгийн үзэл баримтлалыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой.

Байршил: Улаанбаатар, Хөвсгөл, Архангай



Үр дүн:

Үйл ажиллагаа	Зохион/б тоо:	Оролцогчийн тоо:	
МЕНТОРШИП	6	203	ТЭЗ ба ногоон бизнесийн чиглэлд БЖДБЭ-ийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээ"-ний хүрээн дэх "Аялал жуулчлалын салбарын эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, ногоон бизнесийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн нийт 6 менторшип цуврал сургалтыг 2023 оны 8-р сарын 8аас 11-р сарын 9ны хооронд онлайнаар зохион байгуулсан.
СУРГАЛТ	6	306	Аялал жуулчлалын салбар, хүнс, сав баглаа боодлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зорилготой "Тойрог эдийн засаг (ТЭЗ) ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах" зөвлөх үйлчилгээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны захиалга, Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны дэмжлэгтэйгээр IRIM, ToC Холбоо, Хөгжлийн шийдэл ТББ, олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллага болох Adelphi хамтарсан төслийн баг Улаанбаатар, Архангай, Хөвсгөл зэрэг төслийн зорилтот байршлуудад тус тус 2 удаагийн сургалт 5р сарын 30-аас 6р сарын 18ны хооронд хийгдээд байна.
УУЛЗАЛТ	1	194	Аялал жуулчлалын салбар, хүнс, сав баглаа боодлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зорилготой "ТЭЗ ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах" зөвлөх үйлчилгээг БОАЖЯ-ны захиалга, АХБ-ны дэмжлэгтэйгээр IRIM, ToC Холбоо, Хөгжлийн шийдэл ТББ, олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллага болох Adelphi хамтарсан төслийн баг 2022 оны 11 сараас 2024 оны 05 сарын хугацаанд хэрэгжүүлж байна. Уг үйл ажиллагааны Нээлтийн Уулзалт болон эхний Сургалтын үйл ажиллагаа нь 2023 оны 5-р сарын 30-нд Улаанбаатар Галлерей төвийн MG ballroom танхимд амжилттай зохион байгуулагдав.

Үйл ажиллагаа	Зохион/б тоо:	Оролцогчийн тоо:	
ПИТЧ ӨДӨРЛӨГ	1	64	Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын салбар болон хүнсний салбарын эмэгтэйчүүдэд Тойрог эдийн засгийн нэвтрүүлэх ногоон бизнесийг хөгжүүлэх чиглэлээр зарлагдсан “Шилдэг Ногоон Санаачилга” шалгаруулалтын 2-р шатны сонгон шалгаруулалт 2023 оны 12 сарын 28ны өдөр зохион байгуулагдлаа. Энэхүү 2-р шатны бизнес төслөө танилцуулах Pitch event-д Орон нутгаас (Хөвсгөл- 11, Архангай-3) нийт 14, Улаанбаатар хотоос 16, нийтдээ30 БЖДБЭ нар амжилттай оролцлоо.
НИЙТ	14	767	Аялал жуулчлалын салбар, хүнс, сав баглаа боодлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зорилготой “ТЭЗ ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах” зөвлөх үйлчилгээг БОАЖЯ-ны захиалга, АХБ-ны дэмжлэгтэйгээр IRIM, ToC Холбоо, Хөгжлийн шийдэл ТББ, олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллага болох Adelphi хамтарсан төслийн баг 2022 оны 11 сараас 2024 оны 05 сарын хугацаанд хэрэгжүүлж байна. Уг үйл ажиллагааны Нээлтийн Уулзалт болон эхний Сургалтын үйл ажиллагаа нь 2023 оны 5-р сарын 30-нд Улаанбаатар Галлерей төвийн MG ballroom танхимд амжилттай зохион байгуулагдав.

ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН ШИЛЖИЛТ” SOGE ТӨСӨЛ

ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА





“АЗИ ДАХЬ НИЙГЭМ, ЭВ
НЭГДЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ
БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ
СУДАЛГАА”

2022-2024 он

АЗИ ДАХЬ НИЙГЭМ, ЭВ НЭГДЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ СУДАЛГАА

2022-2024 он

Монгол | Камбож | Киргиз | Тайланд | Вьетнам

Олон улсын хөдөлмөрийн байгууллага - International Labour Organization -аас санаачлан Ази дахь Нийгэм, Эв Нэгдлийн Эдийн Засаг (НЭНЭЗ)-ийг Бэхжүүлэх нь төслийн 2-р үе шатыг Монгол, Камбож, Киргиз, Тайланд, Вьетнам улсуудад 2022-2024 онд хэрэгжүүлж байна. ОУХБ-ын тодорхойлолтоор НЭНЭЗ-т Хоршоо, Холбоо, Нөхөрлөл, Сан, Нийгмийн Интерпрайз (Social Enterprise), Хамтын сан болон албан бус бүлгүүд орно.


Энэхүү төсөл судалгааны ажлаар Монгол дахь Нийгэм, эв нэгдлийн эдийн засгийг үндэсний хэмжээнд тодорхойлж, Зохистой хөдөлмөр, Тогтвортой хөгжлийн зорилтод оруулах тэдний хувь нэмрийг олон нийтэд илүү сайн таниулах,

мэдээлэх зорилготой. Мөн цаашлаад судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсын Нийгэм, эв нэгдлийн эдийн засгийг бэхжүүлэх бодлогын зөвлөмж хүргүүлнэ.



ОУХБ-аас боловсруулсан аргачлалын дагуу Хөгжлийн Шийдэл ТББ-ын судалгааны баг НЭНЭЗ-ийн байгууллагуудын үйл ажиллагааг нийгэм, эдийн засаг, байгаль орчны хүрээнд **156** ААН, бүлгүүдээс асуумж судалгаагаар мэдээлэл цуглуулан анализ хийсэн. Цаашлаад тус тоон судалгаанд оролцсон байгууллагуудаас сонгон **20** кейс судалгаагаар НЭНЭЗ-ийн байгууллагуудын зохистой хөдөлмөр эрхлэлт, тогтвортой хөгжлийн зорилтод оруулж буй хувь нэмрийг гүнзгийрүүлэн судаллаа.





“ЗАЛУУЧУУДЫН БИЗНЕСИЙН САНААЧИЛГА -ҮВМ”

2013 оноос одоог хүртэл

ЗАЛУУЧУУДЫН БИЗНЕСИЙН САНААЧИЛГА -YBM

2013 оноос одоог хүртэл

Их Британи, Умард Ирландын Вант Улсад төвтэй Youth Business International ОУБ-ын гишүүнээр 2013 оноос хойш ажиллаж буй Хөгжлийн Шийдэл ТББ нь 2013 Монгол Улсад залуучуудын ажлын байр, бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор Youth Business Mongolia хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд өөртөө болон бусдад ажлын байр бий болгож, энтрепренер болох хүсэлтэй 18-35 насны залууст зориулсан олон үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Үндсэн үйл ажиллагаа:

- Энтрепренершипыг хөгжүүлж, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх
- Шинэ инновацлаг санаа бүхий энтрепренерүүдийг бэлтгэх
- Орон нутагт гарааны бизнесээ эхэлж байгаа залуучуудад дэмжлэг үзүүлэх, тэднийг чадавхжуулах
- Ажлын байрыг нэмэгдүүлэх
- Залуусын хүсэл мөрөөдөл, зорилгыг нийгэмд таниулах
- Сайн дурын бизнес менторуудыг бий болгох
- Нийгмийн болон ногоон энтрепренершипыг дэмжих
- Зах зээл болон санхүүжилттэй холбох үйлчилгээ

2023 онд **3169** энтрепренер залууст сургалт, зөвлөгөө өгч, **321** залуусыг бизнесийн санхүүжилт авахад нь тусалж, **106** залуусыг бизнесийн ментортой болгов.

НИЙГМИЙН БОЛОН НОГООН БИЗНЕСИЙН СУРГАЛТЫН ХЭРЭГСЭЛ БЭЛТГЭХ

Үйл ажиллагааны тоо: **14** удаагийн сургалт, уулзалт

Үр шим хүртэгчийн тоо: **223**

Дэлхий эргэн тойронд буй нийгмийн болон ногоон чиглэлийн гарааны бизнес болон жижиг, дунд бизнесүүдэд дэмждэг байгууллагууд уг бизнесүүдийг хөгжүүлэх хэрэгслүүдийг хийсэн. Эдгээр хэрэгслүүд нь YBI-ийн гишүүн байгууллагуудын мэдлэг, туршлагад тулгуурлан хийгдсэн бөгөөд бизнес санаанаас эхлээд, хөгжүүлэх стратеги хүртэлх өргөн сэдвийг хамрууллаа. YBM хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот болон 12 аймгийн хэмжээнд 223 залуу нийгмийн болон ногоон бизнесийг эрхлэгч нарыг 13 төрлийн хөгжүүлэх хэрэгслээр хангасан төдийгүй, 15 сургагч багшийг бэлтгэн гаргасан. Мөн learning.bizguide.mn сайтад видео хэлбэрээр уг хэрэгслүүдийг хэрхэн ашиглах талаар сургалтыг байршуулсан.

ӨСӨЛТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН УР ЧАДВАРУУД (GPS) СУРГАЛТ

Үйл ажиллагааны тоо: na

Үр шим хүртэгчийн тоо: **NA**

Энэ бол бизнес эрхлэгчийн зөөлөн ур чадварыг хөгжүүлэх, сайжруулах онлайн үнэгүй сургалт юм. Энэхүү сургалтыг 7 модулийн хүрээнд 4 долоо хоногийн туршид 4 цахим уулзалттай үйл ажиллагаатайгаар зохион байгуулсан. 2020 оны COVID-19 цар тахлын үед энэхүү сургалтын хөтөлбөрийг олон бизнес эрхлэгчдийг дэмжих, өөрчлөлтөд илүү сайн дасан зохицох, хямралын үед өөдрөг байхын тулд хэрэгжүүлж болох агуулга, арга хэрэгслийг хуваалцах замаар онлайн үйл ажиллагаа болгож хувиргасан. Үүнээс гадна, УВМ хөтөлбөр нь сургалт, менторинг, болон уулзалтын үйл ажиллагаандаа дээрх онцгой агуулгуудыг оруулсан. Үүнийг learning.bizguide.mn сайтаас авах боломжтой.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙГ ДЭМЖИХ - МЕНТОРИНГИЙН КЭЙС СУДАЛГАА

Үйл ажиллагааны тоо: 2 менторшип уулзалт

Үр шим хүртэгчийн тоо: **30**

Ази эмэгтэй бизнесүүдэд зориулсан Өөрийгөө хөгжүүлэх тусгай сургалтын хөтөлбөр 1 сургалтын хөтөлбөр 5 ETIC нь 1993 онд байгуулагдсан төрийн бус байгууллага бөгөөд Япон дахь нийгмийн өөрчлөлтийн нэр дүнтэй төв юм. 2016 оноос эхлэн Клармонт их сургуулийн Менежментийн Дракер сургуулийн дадлагын профессор Жереми Хантертай хамтран нийгмийн салбарын 260 гаруй удирдагчийг “Өөрийгөө удирдах” хөтөлбөрт хамруулаад байна.

ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ

Үйл ажиллагааны тоо: 12 удаа

300

Энэхүү хөтөлбөрийн Азийн эмэгтэй удирдлагуудад зорилусан тусгай хөтөлбөрт УВМ хөтөлбөрөөс 5 эмэгтэй оролцсон бөгөөд 2023 оны 8-р сараас 10-р сарын хооронд 6 удаагийн онлайн уулзалт, сургалтад оролцсон. Энэ хөтөлбөрийн оролцогч нар дараах үр шимийг хүртсэн. Үүнд:

- Хувь хүн болон удирдагчийн хувьд өөрийн хүсэлт тэмүүлэлийг ойлгож, өөрийн ухамсарыг гүн гүнзгий мэдэж авсан.
- Өөрсдийгөө үр дүнтэй удирдах чадварыг сайжруулсан, сэтгэл санааны сайн сайхан байдлыг өөрийн бодол, үйлдэлтэй нэг түвшинд авчирсан.
- Бусад эмэгтэй удирдлагуудын гайхалтай хичээл зүтгэлийг олж мэдэж, тэдний нийгэмд үйлчилж буй туршлага болон удирдлагын замд нь тулгарч байсан, мөн даван туулсан бэрхшээлүүдийн талаар мэдлэгтэй болсон.
- Олон улсын эмэгтэй удирдлагуудын нэг хэсэг болж, өөрийгөө дэмжих, идэвхжүүлэх суралцах орчныг цэцэглүүлсэн.

“УВМ” хөтөлбөрийн хүрээнд “Өглөөний мэнд” хэмээх сар бүрийн сонирхолтой уулзалтыг зохион байгуулдаг билээ. Туршлагатай зөвлөхүүд, залуу бизнес эрхлэгчид хамтдаа бизнесийн өсөлтийн тушлага хуваалцаж, шинэ харилцаа, холбоо үүсгэдэг. Уулзалат бүрт хоёр хүндэт зочин зөвлөх байдаг бөгөөд уг арга хэмжээ нь аль хэдийн 300 гаруй бизнес эрхлэгчдийг хамруулсан байна.

НИЙГМИЙН БИЗНЕС- 2023 ЧУУЛГАН УУЛЗАЛТ

Үйл ажиллагааны тоо: 1 үйл ажиллагаа

Үр шим хүртэгчийн тоо: **200**

Тус уулзалтад Улаанбаатар хот болон 21 аймагт үйл ажиллагаа явуулдаг 200 гаруй нийгмийн болон ногоон энтрепренерүүд цугларч, нийгмийн бизнес загвараа танилцуулав. Мөн төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудын төлөөллүүд нийгмийн энтрепренершипыг дэмжин ажиллаж буй арга барил, бодит үр дүнгээ хуваалцав.

ҮВИ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОЛИЛЦОН, СУРАЛЦУУЛАХ ХӨТӨЛБӨР

Youth Business International сүлжээний гишүүн байгууллагууд хоорондын туршлага хуваалцах аяны хүрээнд Хөгжлийн Шийдэл ТББ-ын төлөөлөл БНЭнэтхэг улс дахь гишүүн Bharatiya Yuva Shakti Trust байгууллагын Чэннай хот дахь нийгмийн болон ногоон энтрепренерүүдийг дэмжиж буй үйл ажиллагаатай танилцлаа. Нийт 17,000 гаруй ментортой, нэг сая орчим энтрепренер залуучуудыг дэмждэг тус байгууллага нь зах зээлийн холболт, санхүүжилт, ногоон бүтээгдэхүүн хөгжүүлэлт зэрэг үйлчилгээг орон нутгийн захиргаа, их сургууль, МСҮТ, арилжааны банкууд, хувийн хэвшлүүдийн хамтын ажиллагаан дээр суурилан хүргэж байна. Нийгэм, байгаль орчинд ээлтэй бизнесүүд бизнес загвараа КОВИД-19 дараа хэрхэн хөрвүүлсэн талаар олон сонирхолтой мэдээлэл, туршлагыг олж авав.

НИЙГМИЙН ЭНТРЕПРЕНЕРҮҮДИЙН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН УЛААНБААТАР ХОТОД ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ

2023 оны 10 сарын 18-ны өдөр

Хөгжлийн Шийдэл ТББ нь Youth Business International байгууллагын дэмжлэгтэйгээр нийгэм, байгаль дэлхийд ээлтэй эдийн засгийн хөгжлийг хурдасгахын тулд Алсын Хараа 2050 болон Тогтвортой Хөгжлийн Зорилгуудтай уялдуулан бодлого, хэрэгжилтийн түвшинд нийгмийн болон ногоон энтрепренершипийн суурийг бэхжүүлэх зорилготой ажилладаг. Ашигт тулгуурласан уламжлалт бизнесийн загварыг нийгэмд ээлтэй эрхэм зорилготой болгон хөрвүүлэн хөгжүүлснээр тогтвортой хөгжлийг тэтгэх дэлхийн хөдөлгөөнийг

Монгол улсад өрнүүлэх ажилд тус арга хэмжээ 2014 оноос хувь нэмэр оруулж байна.

Тус уулзалтад Улаанбаатар хот болон 21 аймагт үйл ажиллагаа явуулдаг **150** гаруй нийгмийн болон ногоон энтрепренерүүд цугларч, нийгмийн бизнес загвараа танилцуулав. Мөн төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудын төлөөллүүд нийгмийн энтрепренершипийг дэмжин ажиллаж буй арга барил, бодит үр дүнгээ хуваалцав.







“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”

2010 оноос одоог хүртэл



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

2010-одоог хүртэл

Зорилго:

2010 оноос Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны санхүүжилттэй Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн ажлын байр бий болгох, Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, Гарааны бизнесийг дэмжих, Аж ахуй эрхлэлтийг дэмжих зэрэг хөтөлбөрүүдийн хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр Халамжийн Хэлтсүүдтэй хамтран ажиллаж байна.

Үндсэн үйл ажиллагаа:

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийн иргэд болон бизнес эрхлэх, бизнесээ хөгжүүлэх хүсэлтэй иргэн, аж ахуй нэгжүүдэд бизнес хөгжлийг дэмжих сургалт, менторинг, зээл санхүүжилтэд холбох зэрэг үйлчилгээг үзүүлдэг.

Үр дүн:

2023 онд Улаанбаатар хот болон Ховд, Дорноговь, Өмнөговь, Дархан, Өвөрхангай аймгийн Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Газруудтай хамтран нийт 255 иргэн, аж ахуй нэгжийг бизнес эрхлэлтийн болон гарааны бизнесийн сургалт, зөвлөгөөнд хамруулж, ХЭДСангаас 81 бизнесийг 1,8 тэрбум төгрөгийн санхүүжилт авахад нь зөвлөгөө өгсөн байна.

НИЙСЛЭЛИЙН ШИЛДЭГ ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ШАЛГАРУУЛАХ START-UP АРГА ХЭМЖЭЭ

Хөгжлийн Шийдэл ТББ нь 2017 оноос Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Сангийн санхүүжилттэй шилдэг гарааны бизнесийг шалгаруулах START-UP арга хэмжээг зохион байгуулж байгаа бөгөөд 2023 онд Хан-Уул болон Сонгино Хайрхан дүүргийн шилдэг гарааны бизнесийг шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаа.

Тус хөтөлбөрийн Boot camp сургалтад Сонгинохайрхан болон Хан-Уул дүүргийн 18-34 насны нийт 58 залуучууд хамрагдаж бизнес санаагаа хөгжүүлсэн бол Хурдасгуур хөтөлбөрт 13 багийн 23 залуус хамрагдсан. 13 багаас 5 багийн бизнес санаа тус бүр 10 сая төгрөгийн санхүүжилт авлаа.



Амжилтын түүх

“Их Чандманьт Очир” ХХК нь 2018 онд байгуулагдаж анхны бүтээгдэхүүнээ худалдаанд гаргасан. Одоогоор 10 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Монгол малын арьс ширээ эдийн засгийн эргэлтэд оруулах, экспортын бүтээгдэхүүн болгох зорилготой.

Өрхийн үйлдвэрлэлээс гарааны бизнесээ эхлүүлж, турших, судлах гээд их эрэл хайгуулын үед Хөгжлийн Шийдэл ТББ-тай танилцан бизнесийг хөгжүүлэх хурдасгуур хөтөлбөр болон зөвлөгөөнд хамрагдсаар хөнгөлөлттэй зээл, болон бүтээгдэхүүн хөгжүүлэх, бизнесээ тэлэх боломжуудын талаар бодитой, хэрэгжихүйц, амьдралд ойрхон мэдээлэл, мэдлэгээр цэнэглэгдсэн. Мөн Залуучуудын гарааны бизнесийг дэмжих Нийслэлийн START-UP арга хэмжээнд амжилттай оролцож шилдэг багаар шалгарч Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Сангаас 10,0 сая төгрөгийн санхүүжилт авч чадсан. Гарааны бизнесийн санхүү гэдэг өөрөө өрхийн санхүүтэй холиолдож явах нь буруу юм гэдгийг анх сургалтдаа суугаад л ойлгож бага багаар зөвлөхүүдийнхээ зөвлөгөөг хэрэгжүүлснээр “Их Чандманьт Очир” ХХК-г байгуулж, үндсэн 4 ажилтантай ЖДҮ шалгуур хангасан компани болжээ.



“Их Чандманьт Очир” ХХК –ийн Захирал
М.Бадамренчин:

“Эзэн нь хичээвэл заяа хичээнэ гэсэн үгийн биелэл Хөгжлийн Шийдэл ТББ-тэй танилцсанаар маш олон хүртээмжтэй, бодит боломж, үнэт зөвлөгөөнүүдийн хамт ирсэн”.



МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ДУНД ШАТНЫ ХОРООДЫГ ЧАДАВХЖУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хөгжлийн Шийдэл ТББ нь МУЗН-ийн Дунд Шатны Хороодыг чадавхжуулах зөвлөх үйлчилгээг үзүүлсэн. Зөвлөх үйлчилгээний хүрээнд МУЗН-ийн 33 дунд шатны хороодын бие даасан байдлыг хангах зорилгоор Нийгмийн бизнес моделийг тодорхойлж Нийгмийн бизнес эхлүүлэхэд көүчинг, зөвлөх үйлчилгээг үзүүлэв.

Энэхүү зөвлөх үйлчилгээний үр дүнд МУЗН-ийн 33 Дунд Шатны Хороодоос 7 Дунд шатны хороод нь 210 сая төгрөгийн санхүүжилт татаж Нийгмийн бизнес төслүүдээ амжилттай эхлүүлэв. Нийгмийн бизнес төслийн хүрээнд МУЗН-ийн Дунд Шатны Хороодын сайн дурын ажилтнууд, тусламж дэмжлэг хүртэгчдийг татан оролцуулах замаар бие даасан байдлаа хангах орлогын эх үүсвэртэй болж гамшгийн үед ашиглах тусламжийн нөөцөө бүрдүүлж байгаа юм.



ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ-ЫН ТҮНШЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЖИЖИГ, ДУНД
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



Европын Холбоо
санхүүжүүлэв



WORLD BANK

ybi | Youth
Business
International



Food and Agriculture
Organization of the
United Nations



International
Labour
Organization



БОГД БАНК
ИТЭГН ИТЭЭНЭ



TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ГОЛОМТ БАНК

MMCI
Management Management Center/Institute



ХААН БАНК



ХАСБАНК



DMUV



STARTUP
MARKETING
SPACE

